



255

# БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 4/338

Булган

## Комисс томилох тухай

Монгол Улсын Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор баталсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 3.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган сумын 1 дүгээр багийн нутаг, "Мобиком" ХХК-ийн антеннийн барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга

- Ц.Бат-Өлзий /Аймгийн Засаг даргын орлогч/

Гишүүд:

- Б.Ганзориг /ГХБХБГ-ын барилгын хэлтсийн дарга/
- Н.Очирхуяг /Аймгийн МХГ-ын барилгын техник, авто замын хяналтын улсын байцаагч/
- Ж.Эрдэнэбулган /Аймгийн Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч, дэслэгч/
- О.Отгонбаяр /"Мобиком" ХХК-ийн барилга захиалагчийн инженер/
- Ш.Оюундарь /"Өрнөлпроект" ХХК-ийн захирал/
- И.Бүрэн-Эрдэнэ /"Хүрэлцам" ХХК-ийн захирал/
- Т.Дорж /Аймгийн архивын тасгийн дарга/
- Д.Нарангэрэл /Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн/

Нарийн бичгийн дарга

2. Цахилгаан дамжуулах агаарын шугамыг ашиглалтад оруулах үйл ажиллагааг 2018 оны 06 дугаар сарын 06-ны дотор багтаан зохион байгуулахыг комисс /Ц.Бат-Өлзий/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

*Ц.Бат-Өлзий*

З.БАТЗОРИГ